



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/115

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Улаанбаатар-Мандалговь, Мандалговь-Даланзадгад чиглэлийн улсын чанартай авто замын засвар арчлалт хариуцсан “Ялгуусан” ХХК-ний арчлалт хамгаалалт, бэлэн байдлыг хангах, мөнгө хураах цэгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Барилга хот байгуулалт, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Онцгой байдлын газрын дарга
Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга
Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техник, авто замын хяналтын улсын байцаагч
Авто тээврийн төвийн дарга
“Ялгуусан” ХХК-ний менежер

Хоёр. Улаанбаатар-Мандалговь, Мандалговь-Даланзадгад чиглэлийн улсын чанартай авто замын засвар арчлалт хариуцсан “Ялгуусан” ХХК-ний сарын хийсэн ажлын тайланг авч, газар дээр нь шалгаж, хөндлөнгийн хяналтыг Зам тээврийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 01/5044 албан тоотын хавсралтын дагуу шалгаж, үнэлгээг Зам тээврийн яам руу хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга/-т даалгасугай.

023880306

Гурав. Улирал болгоны сүүлийн сарын 4 дэх 7 хоногийн пүрэв гаригт аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж байхыг ажлын хэсгийн гишүүн /"Ялгуусан" ХХК-ний менежер/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/467 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ